



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай
холбогдуулан ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.1.3, Засгийн газрын 2021 оны 91,104,105 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 18, 37 дугаар тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 07 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/313 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, тархалтыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийг дуустал хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр ажилтан, албан хаагчдыг ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулсугай.

2. Хязгаарлалт тогтоосон хугацаанд газрын ажилтан, албан хаагчдыг ажлын байранд ажиллуулахгүй байх, зайлшгүй шаардлагаар биечлэн ажиллах албан хаагчдын тоог бууруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажлын тусгай горимоор (цахимаар, ээлжээр, богиносгосон цаг) ажиллах хуваарь гарган батлуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (Г.Энхтуяа), Үйлчилгээний алба (М.Алтантуяа), Байр ашиглалтын алба (Г.Батзаяа) -ны дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан хуваарийн дагуу албан хаагчдыг ажиллуулж, хувийн болон нийтийн тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцох боломжийг нь бүрдүүлж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Ч.Шинэчимэг/-т үүрэг болгосугай.

4. "Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хавсралтад өөрчлөлт орсонтой холбогдуулан Нийслэлийн засаг захиргааны байруудын хэмжээнд сурталчлан таниулж, хэрэгжүүлж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг Үйлчилгээний алба (Албаны дарга, менежерүүд)-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Орлогч дарга Ч.Однасан, Б.Галмандах, Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Шинэчимэг нарт даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

C:\Users\Desktop\A tushaal.docx

1150500057